

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА

АУДИТЫН КОД: БНА-2021/56-ШТА-ГА

Баянхонгор хот 2021 он 05 сар

**Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор П.Амаржаргал

Утас: 88106996 цахим хуудас: amarjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| Товчилсон үгийн тайлбар | 2 |
| Хүснэгтийн товьёг | 3 |
| Дүрслэлийн товьёг..... | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл | 4 |
| БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ, ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ ХИЙХГҮЙ БАЙНА..... | 6 |
| 1.1 Ангилагдаагүй зардалд батлагдаж байгаа орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагын судалгаа байхгүй, үүрэг хэрэгжүүлэгч бодлогын хэлтэс нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс төлөвлөлтийн бодлого алдагдсан байна | 6 |
| 1.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төслийг аймгийн төсөв баталснаас хойш боловсруулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна..... | 7 |
| 1.3. Зарим хөрөнгө оруулалтын ТАХ аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй байна..... | 7 |
| БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ГЭРЭЭН ЗААСНЫ ДАГУУ БҮРЭН ОЛГОСОН БАЙХАД, ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХУГАЦААНДАА БҮРЭН ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА..... | 8 |
| 2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу цахимаар зохион байгуулсан боловч Баянхонгор сумын Засаг дарга нь ТБОНӨХБАҮХАТХ зөрчиж, тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна | 8 |
| 2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн гэрээний зарим ажил дутуу, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй зөрчилд эрх бүхий байгууллага нь арга хэмжээ авч ажилласан байна. 12 | 12 |
| 2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг гэрээний дагуу бүрэн олгосон байна. | 18 |
| 2.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүйгээс гэрээнд заагдсан зарим ажил бүрэн хийгдээгүй, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй бараа, ажил хүлээн авсан бөгөөд гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй байна | 19 |
| БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ, ЗАРИМ ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХ ЭРХИЙН ЗӨРЧИЛТЭЙ БАЙНА .. | 20 |
| 3.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр дүнг тооцдоггүй зөрчил давтагдан гарч байна..... | 20 |
| 3.2. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн боловч зарим хөрөнгө эзэмших эрхийн зөрчилтэй байна..... | 22 |
| ДҮГНЭЛТ: | 25 |
| ЗӨВЛӨМЖ: | 26 |

Товчилсон үгийн тайлбар

| | |
|--------------|--|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэр |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| БСУГ | Боловсрол, соёл урлагийн газар |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |

Хүснэгтийн товьёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-----------|---|-----------------|
| Хүснэгт 1 | Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ | 8 |
| Хүснэгт 2 | Худалдан авах ажиллагаанд хамааралгүй ТАХ-ний судалгаа | 10 |
| Хүснэгт 3 | Ангилалдаагүй зардлаас 2019 онд эрх шилжүүлсэн төсвийн судалгаа | 10 |
| Хүснэгт 4 | 2020 оны худалдан авах ажиллагаанд хамааралгүй ТАХ-ний судалгаа | 11 |
| Хүснэгт 5 | Ангилалдаагүй зардлаас 2020 онд эрх шилжүүлсэн төсвийн судалгаа | 12 |
| Хүснэгт 6 | Авто замын сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ | 12-13 |
| Хүснэгт 7 | Авто замын сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ | 14 |
| Хүснэгт 8 | Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн судалгаа | 18 |

Дүрслэлийн товьёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-----------|---|-----------------|
| Дүрслэл 1 | Ангилалдаагүй зардлаас 2019, 2020 онд санхүүжүүлсэн ТАХ-ний ангилал | 15 |
| Дүрслэл 2 | Ангилалдаагүй зардлаар бэлтгэсэн авто машины талаарх мэдээлэл | 15 |
| Дүрслэл 3 | ЖДҮ-ийн үр дүнд бий болсон ажлын байрны судалгаа | 21 |

| | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл |
|---|---|
| Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх | Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Аудитын 2021 оны төлөвлөгөө”-г үндэслэн “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв. |
| Аудитын зорилт | <p>“Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх ➤ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх |
| Аудитын хамарсан хүрээ | Аудитыг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019, 2020 онд орон нутгийн “Ангилалдаагүй зардал”-ын жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээ, “Авто замын сан”-гийн хөрөнгөөр батлагдан, хэрэгжсэн төсөл арга хэмжээ болон 2020 онд урсгал төсвөөс бэлтгэсэн хөрөнгө оруулалтыг хамруулан гүйцэтгэлээ. |
| Аудитын хязгаарлалт | Аудитад ангилалдаагүй зардалд багтсан хөрөнгө оруулалтын бус шинж чанартай хөтөлбөр, арга хэмжээнүүд, замын сангийн орлого бүрдүүлэлтийг хамааруулан шалгаагүй болно. |
| Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт | Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүй, Монгол Улсын стандарт-Төрийн аудит MNS6817:2020-ыг ашиглан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. |
| Аудитын бүрэлдэхүүн, хугацаа | Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор П.Амаржаргал нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийн дагуу гүйцэтгэв. |
| Хүндрэл бэрхшээл | <p>Аудитын төлөвлөгөөг 2021.03.22-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2021.03.22-ны өдрөөс 2021.04.30-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2020.04.30-наас холбогдох үе шатны хяналтаар хянуулан Газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.</p> <p>1. Цар тахлын арга хэмжээний хүрээнд 2021.04.02-ний өдрөөс 2021.05.08-ний өдөр хүртэл хөл хориотой байснаас объект дээр ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн нь аудитыг цаг хугацаандаа гүйцэтгэж дүнг танилцуулахад хүндрэл учирсан болно.</p> |

**Үндсэн
мэдээлэл**

2019 онд

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 14/03 тоот “Аймгийн 2019 оны төсвийн тухай” тогтоолоор ангилагдаагүй зардлыг 24 төсөл, арга хэмжээний 1,756,920,4 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд Аймгийн ИТХ-ын 2019.04.19-ний №16/02, 16/03 тоот тогтоол, Аймгийн Засаг даргын 2019.09.24-ний А/489, 2019.12.16-ний А/645 тоот захирамжуудаар өөрчлөлт оруулсан оны эцэст 2,400,229.3 мянган төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас хөрөнгө оруулалтын шинж чанартай 1,338,856.9 мянган төгрөгийн 22 төсөл арга хэмжээ батлагджээ.

Замын сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг 13 төсөл арга хэмжээний 706,089,6 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлагдсаныг аймгийн ИТХ-ын 2019.04.19-ний №16/02 тогтоолоор 198,568,8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 904,658.6 мянган төгрөгийн 17 төсөл арга хэмжээ болгож өөрчилжээ.

2020 онд

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 18/16 тоот “Аймгийн 2020 оны төсвийн тухай” тогтоолоор ангилагдаагүй зардлыг 33 төсөл, арга хэмжээний 3,621,500.0 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд Аймгийн ИТХ-ын 2020.09.18-ний 18/16 тоот тогтоол, Аймгийн Засаг даргын 2020.05.19-ний А/347, 2020.07.09-ний А/446, 2020.10.27-ны А/701, 2020.12.31-ны А/850 тоот захирамжуудаар өөрчлөлт оруулсан оны эцэст 3,308,029.2 мянган төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас хөрөнгө оруулалтын шинж чанартай 1,575,401.0 мянган төгрөгийн 21 төсөл арга хэмжээний батлагджээ.

Замын сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг 11 төсөл арга хэмжээний 720,000.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд оны эхний үлдэгдлээс 20,664.1 мянган төгрөгийг нэмж 740,664.1 мянган төгрөгийн 15 төсөл арга хэмжээ болгон өөрчилсөн байна.

Мөн 2020 онд Ерөнхий боловсролын сургуулиудад 706,244.1 мянга, Сургуулийн өмнөх боловсролд 265,747.5 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн ба аймгийн БСУГ-аас 220,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хот тохижилтын 2020 оны төсөвт батлагдсан ногоон байгууламжийн ажилд 65,480.0 мянган төгрөг батлагджээ.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ, ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ ХИЙХГҮЙ БАЙНА

1.1 Ангилагдаагүй зардалд батлагдаж байгаа орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагын судалгаа байхгүй, үүрэг хэрэгжүүлэгч бодлогын хэлтэс нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс төлөвлөлтийн бодлого алдагдсан байна

Аймгийн хэмжээнд баримтлах хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, хөтөлбөр төслийг боловсруулж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулах, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүргийг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХБХОТХ гэх/ хүлээсэн байна.

Гэвч Баянхонгор аймгийн хэмжээнд 2019, 2020 онд батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл явцын талаар аймгийн ЗДТГ-ын ХБХОТХ-ийн мэргэжилтнээс тодруулахад “Манай хэлтэс нь ангилагдаагүй зардлыг хариуцдаггүй, СТСХ-ээс хариуцаж байгаа” гэсэн тайлбарыг өгөв.

Харин аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн нь “Манай хэлтэс төлөвлөлт хийхдээ орон нутгийн орлогоос хамаарч ангилагдаагүй зардлын нийт дүнг гаргаж ХОХБТХ-т өгдөг, харин задаргааг гаргахдаа ХОХБТХ-ээс гаргаж өгдөг, хэрхэн төлөвлөдөг, яаж эрэмбэлж дүнг тогтоож байгааг мэдэхгүй” гэсэн тайлбар өгөв.

Аудитын илрүүлэлт:

Дээрх байдлаас үзэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ баримтжуулдаггүй, анхан шатны нэгжид хэрэгцээ шаардлагын судалгаа гаргадаггүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг урьдчилан тооцдоггүй аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь төлөвлөлтийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ аймгийн хэмжээний төсөв захирагчдын хэрэгцээ шаардлагыг судалж, хэрэгцээ шаардлагыг эрэмбэлэн, хүрэх түвшнийг тодорхойлон, эдийн засгийн үр ашиг, нийгмийн үйлчилгээний хүртээмж, бусад холбогдох ач холбогдлоор нь эрэмбэлэн төлөвлөлтийг зохистой хийх албан шаардлагыг ХОХБТХ-т хүргүүлж, чиг үүргээ хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг Засаг даргад хүргүүлэв.

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

1.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төслийг аймгийн төсөв баталснаас хойш боловсруулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна

Замын сангийн хөрөнгөөр 2019 онд батлагдсан ТАХ-ээс урьдчилан зураг, төсөв шаардагдах нийт 747,288.2 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээ байгаагаас 96,479.3 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээний зураг төсвийг аймгийн төсөв батлагдах үед хийж гүйцэтгэсэн байна.

Харин 2020 онд шинээр батлагдсан нийт 389,407.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээнээс 298,109.0 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээ нь зураг төсөв, болон урьдчилан тооцоолол шаардлагатай байгаагаас 200,000.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь урьдчилан батлагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Замын сангийн 2019 оны хөрөнгө оруулалтаас 650,538.9 мянган төгрөгийн 11 ТАХ, 2020 оны 98,109.0 мянган төгрөгийн 7 ТАХ нь урьдчилан боловсруулсан зураг төсөв боловсруулахдаа баг хороо, авто тээврийн төв, замын цагдаа зэрэг анхан шатны нэгжээс санал аваагүй, зураг төсөв боловсруулсан он сар өдөр байхгүй, магадлалын дүгнэлт, зураг төсөв боловсруулахдаа төсөв батлагдснаас хойш хийлгэсэн зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 29,4²-т дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулахдаа замын цагдаа баг хорооны саналыг авч, зураг төсвийг урьдчилан боловсруулж, магадлалын дүгнэлт гаруулсны дараа төсөвт тусган батлуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.3. Зарим хөрөнгө оруулалтын ТАХ аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй байна

Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг 2019, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг он бүрээр авч 2019, 2020 онд ИТХ-аар баталсан “Ангилалдаагүй зардал” болон “Авто замын сан”-гийн хөрөнгөөр хийхээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалттай аудитын явцад тулгалт хийлээ.

Аудитаар Замын сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд үндсэн чиглэлд бүрэн туссан байсан бол 2020 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд Загийн гол, Бөмбөгөрийн Өлзийт гол, Түйн гол, Нарийн голын хоолтын гармуудад төмөр бетонон гүүрний зураг хийлгэх 80,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ нь тусаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Харин ангилагдаагүй зардалд батлагдсан ТАХ-үүдээс 2019 онд 22,400.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээг, 2020 онд 177,101.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг 2019, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаагүй байна.

² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Хүснэгт № 1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ

| № | Үндсэн чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан дүн |
|---------------------|--|------------------|
| 2019 онд | | |
| 1 | Бууцагаан сумын Хуучин ЗДТГ-ын барилга худалдаж авах /Онцгой байдлын газар/ | 12,900.0 |
| 3 | Цагдаагийн газрын тоног төхөөрөмж | 9,500.0 |
| 2019 оны дүн | | 22,400.0 |
| 2020 онд | | |
| 1 | Газрын даамлуудыг GPS тоног төхөөрөмжөөр хангах | 37,400.0 |
| 2 | Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авах | 40,000.0 |
| 3 | Татварын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах | 29,701.0 |
| 4 | Баянхонгор аймгийн агаарын тээврийн нислэгийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх | 70,000.0 |
| 2020 оны дүн | | 177,101.0 |

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “аймгийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй уялдуулан зорилтод хүрэх түвшнийг тодорхойлсон төсөл арга хэмжээ баталж байх зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ГЭРЭЭНД ЗААСНЫ ДАГУУ БҮРЭН ОЛГОСОН Ч ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХУГАЦААНДАА БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу цахимаар зохион байгуулсан боловч Баянхонгор сумын Засаг дарга нь ТБОНӨХБАҮХАТХ зөрчиж, тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна

Замын сангийн хөрөнгөөр 2019, 2020 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нийт 1,047,397.0 мянган төгрөгийн 14 төсөл арга хэмжээнд аудит хийв.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийт 904,658.4 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсны 150,956.6 мянган төгрөг нь өмнөх оноос шилжиж ирсэн, 49,695.5 мянган төгрөгийг албан журмын даатгалд, 10,461.1 мянган төгрөгийн Автозамын тухай хуулийн 24.5³ дах заалтын дагуу хяналтын зардалд баталсан бол 693,545.2 мянган төгрөгийн 12 төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын ажил шинээр хийхээр төлөвлөсөн байна.

Дээрх 693,545.2 мянган төгрөгийн 12 төсөл арга хэмжээнээс 28,000.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаж 665,454.0 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

³ Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ;

Замын сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн бүх төсөл, арга хэмжээг аймгийн Орон нутгийн өмчийн газар нь цахимаар зарласан бөгөөд 2019 оны 665,454.0 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээнээс 501,195.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 164,350.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна. Нээлттэй тендер шалгаруулалтад дунджаар 57 хоног, харьцуулалтын аргаар шалгаруулсан худалдан авалтад дунджаар 74 хоног зарцуулсан нь ба энэ нь “Гэр хорооллын гэрэлтүүлэг”-ийн ажлын үнэлгээний хороог 2018.12.05-нд байгуулж, худалдан авах ажиллагааг 2019 оны 06-р сард зохион байгуулсантай холбоотой байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үр дүнд 24,384.9 мянган төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсон байна.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийт 740,664.1 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсны 351,257.1 мянган төгрөг нь өмнөх оноос шилжиж ирсэн, 11,298.0 мянган төгрөгийг Автозамын тухай хуулийн 24.5⁴ дах заалтын дагуу хяналтын зардалд баталсан бол 378,109.0 мянган төгрөгийн 10 төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөсөн байна.

Дээрх 378,109.0 мянган төгрөгийн 10 төсөл арга хэмжээнээс 50,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай тогтоолын дагуу шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаж 328,109.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 120,000.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээг, харьцуулалтын аргаар 128,109.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээг, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах аргаар 160,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 80,000.0 төгрөгийн санхүүжих дүн бүхий 1 төсөл арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.

Аудитаар Замын сангийн хөрөнгөөр 2019, 2020 онд зохион байгуулсан тендерт шалгарсан гүйцэтгэгчийн материалыг тендер зохион байгуулахдаа тавьсан шаардлагатай нийцсэн эсэхийг түүвэрлэн шалгахад зөрчилтэй асуудал илрээгүй.

Ангилагдаагүй зардалд 2019 онд нийт 1,454,956.9 мянган төгрөгийн 22 хөрөнгө оруулалтын ТАХ батлагдсаны 828,190.9 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бол 33,966.0 мянган төгрөгийн 4 төсөл

⁴ Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ;

арга хэмжээ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу шууд худалдан авалтаар авсан байна.

Харин үлдсэн 544,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд дараах төсөл арга хэмжээ багтаж байна. Үүнд:

Хүснэгт №2 2019 оны худалдан авах ажиллагаанд хамааралгүй ТАХ-ний судалгаа

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан төсөв |
|---|--|------------------|
| 1 | 6-р байрны иргэдэд орон сууцны хөнгөлөлт үзүүлэх | 45,000.0 |
| 2 | Баянхонгор сумын 3 дугаар байрны дахин төлөвлөлт | 90,000.0 |
| 3 | Бууцагаан сумын Хуучин ЗДТГ-ын барилга худалдаж авах /Онцгой байдлын газар | 129,000.0 |
| 4 | Утааг бууруулах ажлын хүрээнд Цахилгаан халаагуураар иргэдийг хангах | 100,000.0 |
| 5 | Их богд зам” ХХК-д шүүхийн шийдвэрээр | 180,000.0 |
| | Нийт дүн | 544,000.0 |

Аудитын илрүүлэлт:

Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 828,190.9 мянган төгрөгийн 13 ТАХ-нээс 535,180.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг сумдад болон ашиглагч байгууллагад эрх шилжүүлэхдээ 1,200.0 мянган төгрөгийн төсвийн эрхийг илүү шилжүүлсэн нь төсөвт ачаалал үүсгэх эрсдэл үүсгэсэн байна.

Хүснэгт № 3 Ангилагдаагүй зардлаас 2019 онд эрх шилжүүлсэн төсвийн судалгаа

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан төсөвт өртөг | Эрх шилжүүлсэн байгууллага | Эрх шилжүүлсэн дүн |
|---|---|-------------------------|------------------------------------|--------------------|
| 1 | Нэгдсэн эмнэлэг, моргт хөлдөөгч худалдан авах зардал | 19,880.0 | Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг | 19,880.0 |
| 2 | Сумдын автомашин | 225,300.0 | Гурванбулаг сумын ЗДТГ | 50,000.0 |
| | | | Баянхонгор сумын ЗДТГ | 17,500.0 |
| | | | Баянбулаг сумын ЗДТГ | 40,000.0 |
| | | | Баацагаан сумын ЗДТГ | 36,500.0 |
| | | | Өлзийт сумын ЗДТГ | 36,500.0 |
| | | | Баянлиг сумын ЗДТГ | 46,000.0 |
| 3 | Соёл урлагийн байгууллагуудад автомашин худалдан авах | 200,000.0 | Баянлиг сумын Соёлын төв | 28,000.0 |
| | | | Баян-Овоо сумын Соёлын төв | 28,000.0 |
| | | | Гурванбулаг сумын Соёлын төв | 28,000.0 |
| | | | Өлзийт сумын Соёлын төв | 28,000.0 |
| | | | Заг сумын Соёлын төв | 28,000.0 |
| | | | Хөгжимт драмын театр | 30,000.0 |
| | | | Биеийн тамир спортын газар | 30,000.0 |
| 4 | 2,3,7,9 дүгээр багийн камержуулалт | 40,000.0 | Баянхонгор сумын ЗДТГ | 40,000.0 |
| | Дүн | 485,180.0 | | 486,380.0 |

Иймд цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний эрх шилжүүлэхдээ багцаар баталсан төсөл арга хэмжээний үнийн дүнг хянаж батлагдсан төсвийн хүрээнд эрх шилжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засагд даргад зөвлөв.

Аймгийн ОНӨГ нь 341,810.9 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд сонгон шалгаруулсан материалд аудит хийхэд ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Ангилалдаагүй зардалд 2020 онд нийт 1,575,401.0 мянган төгрөгийн 21 хөрөнгө оруулалтын ТАХ батлагдсаны 563,101.0 мянган төгрөгийн 12 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бол 19,300.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу шууд худалдан авалтын гэрээг байгуулан ажилласан байна.

Харин 993,000.0 мянган төгрөгийн дараах 6 төсөл арга хэмжээ нь өмнөх оны гэрээний үлдэгдэл санхүүжилт ба жижиг дунд үйлдвэрийг дэмжин зорилгоор олгогдож буй зээлийн санхүүжилт байна. Үүнд:

Хүснэгт № 4 2020 оны худалдан авах ажиллагаанд хамааралгүй ТАХ-ний судалгаа

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан төсөв /мян.төг/ |
|---|---|----------------------------|
| 1 | Баянхонгор сумын 3 дугаар байрны дахин төлөвлөлтийн үлдэгдэл олгох | 180,000.0 |
| 2 | Баянхонгор сумын Номгон, Рашаант багийн төвийн үлдэгдэл | 198,000.0 |
| 3 | Нийтийн тээврийн үйлчилгээнд "Эко автобус" төсөл хэрэгжүүлэх | 280,000.0 |
| 4 | Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих | 200,000.0 |
| 5 | Баянговь сумын цэцэрлэгт хүрээлэн, наадмын цогцолборын барилгын дэмжлэг | 100,000.0 |
| 6 | Шинэ суурьшлын бүсийн айл өрхийг хашаажуулахад дэмжлэг | 350,000.0 |
| | Нийт дүн | 993.000,0 |

Ангилалдаагүй зардалд 2020 онд батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс 220,000.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээг нийт 4 сумын Засаг даргад эрх шилжүүлсэн бөгөөд сумдын ЗДТГ-ууд тендер сонгон шалгаруулалт зарласан байна. Тендертэй холбоотой хэмнэлт үүсээгүй бөгөөд Баян-Овоо сумын ЗДТГ нь тээврийн хэрэгслийг худалдан авах гэрээний дүн 55,000.0 мянган төгрөг байсан бөгөөд зөрүү 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн сумын нутаг дэвсгэрт алт олборлолтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас гарган төлсөн тухай холбогдох албан тушаалтан тайлбар өгч байна. Үүнд:

Хүснэгт № 5 Ангилагдаагүй зардлаас 2020 онд эрх шилжүүлсэн төсвийн судалгаа

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан төсөвт өртөг | Эрх шилжүүлсэн байгууллага | Эрх шилжүүлсэн дүн |
|---|--|-------------------------|----------------------------|--------------------|
| 1 | Сумдын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх | 120,000.0 | Жинст | 40,000.0 |
| | | | Баян-Овоо | 40,000.0 |
| | | | Заг | 40,000.0 |
| 2 | Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авах | 40,000.0 | Баянхонгор сум | 40,000.0 |
| 3 | "Төмс, хүнсний ногоо 4" төсөл хэрэгжүүлэх | 60,000.0 | Баянхонгор сум | 60,000.0 |
| | Дүн | 220,000.0 | | 220,000.0 |

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор сумын Засаг дарга нь Жимс жимсгэнийн тариаланг дэмжих 60.000,0 мянган төсөл арга хэмжээний хүрээнд 48,000.0 мянган төгрөгөөр тариаланчдыг цахилгаан эх үүсвэрээр хангах, 12,000.0 мянган төгрөгөөр гүний худаг гаргах ажлын гүйцэтгэчийг сонгон шалруулалгүйгээр "Эй Эн Ди" ХХК-тай шууд гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33⁵ дугаар зүйлийг зөрчсөн байна.

Иймд хууль зөрчиж босго үнийг баримтлалгүй шууд худалдан авалт хийсэн Баянхонгор сумын Засаг даргад ТБОНӨХБАҮХАТ хуульд заасан хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

Аймгийн ОНӨГ нь 343,101.0 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэгч сонгон шалгаруулсан материалд аудит хийхэд ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй болно.

2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн гэрээний зарим ажил дутуу, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй зөрчилд эрх бүхий байгууллага нь арга хэмжээ авч ажилласан байна.

Замын сангийн хөрөнгөөр 2019 онд 904,958.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,605,394.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 844,501.8 мянган төгрөгийн 15 хөрөнгө оруулалтын ТАХ батлагдан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.

Хүснэгт № 6. Авто замын сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | ИТХ-аар баталсан дүн | Гүйцэтгэгчийн нэр | Гэрээ байгуулсан дүн | Гэрээ байгуулж, Хүлээн авсан огноо |
|---|--|--------------|----------------------|----------------------------|----------------------|------------------------------------|
| 1 | Явган хүний /1440м2/ болон дугуйн замын /960м2/ ажил | 117,877.3 | 82,514.1 | "Их богд зам" ХХК | 117,877.3 | 2019.06.06, 2019.09.02 |
| 2 | Жишиг гудамж төсөл /МХГ-ын уулзвараас Солонго бичиг хэргийн дэлгүүрийн уулзвар хүртэл/ | 76,975.6 | 14,699.6 | "Алтан завьяа ундарга" ХХК | 76,975.6 | 2020.11.01, 2019.11.08 |

⁵ Харьцуулалтын арга

Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

| | | | | | | |
|---------------------|---|--------------------|------------------|--|--------------------|---------------------------|
| 3 | Аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад засвар хийх | 59,251.0 | 59,251.0 | "Их богд зам" ХХК | 59,181.1 | 2019.06.25, 2019.07.20 |
| 4 | Номгон сургууль, гэр хорооллын дундах бетон хучилттай авто замын хурд сааруулагчийг засварлах | 10,000.0 | 10,000.0 | "Их богд зам" ХХК | 10,000.0 | 2019.08.01, 2019.08.27 |
| 5 | Мазаалай паркаас аюулгүй тойрог хүртэлх, Татварын уулзвараас Байдраг кино театр хүртэлх, Нэгдэлчин буудлын уулзвараас захын ар талын замаар "МТ" ШТС хүртэлх явган хүний зам хийх | 141,170.9 | 141,170.9 | "Их богд зам" ХХК | 140,952.0 | 2019.06.25, 2019.07.24 |
| 6 | Гудамжны гэрэлтүүлэг | 187,231.3 | 187,231.3 | "Эйч Ар Ви Констракшн" ХХК | 169,318.2 | 2019.08.15 |
| 7 | Баянхонгор сумын 4 дүгээр багийн гудамжны гол замыг засах | 5,000.0 | 5,000.0 | "Баянхонгор-тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ | 10,000.0 | 2019.08.01 |
| 8 | Баянхонгор сумын 5 дугаар багийн гудамжны гол замыг засах | 5,000.0 | 5,000.0 | | | |
| 9 | Баянхонгор аймгийн төв замын Солонго бичиг хэргийн дэлгүүрийн хойд уулзвараас МХГ-ын урдах уулзвар хүртэлх авто замын хучилтыг шинэчлэн засварлах | 97,792.9 | 97,792.9 | "Их богд зам" ХХК | 97,792.9 | 2019.07.16 |
| 10 | Стадионы гадна талбайн зогсоол | 47,092.7 | 47,092.7 | "Эх Өлзийт Богд" ХХК | 46806.32 | 2019.07.20 |
| 11 | Автозамын тэмдэг тэмдэглэгээний засвар | 15,000.0 | 15,000.0 | "Итгэлт тайж" ХХК | 14,802.2 | 2019.11.25 |
| 12 | Өлзийт сумын Нарийн голын гялгарын Хавцгайн багийн замын засах | 40,000.0 | 8,000.0 | "Тэргүүн дээвэр" ХХК | 40,000.0 | 2018.12.05 |
| 13 | Гэр хорооллын гэрэлтүүлэг | 43,006.4 | 43,006.4 | "Баянхонгор-Эрчим хүч" ХХК | 36,999.8 | 2019.10.12 |
| 14 | Баянхонгор сумын төвд 1 км хатуу хучилттай авто зам барих /Баянхонгор аймаг Баянхонгор сум/ | 379,996.6 | 75,000.0 | "Их богд зам" ХХК | 379,996.6 | 2019.07.19 |
| 15 | Баянхонгор сумын төвд 1 км хатуу хучилттай авто зам барих /Баянхонгор аймаг Баянхонгор сум/ | 380,000.0 | 53,742.9 | "Их богд зам" ХХК | 380,000.0 | Он дамжин хэрэгжсэн |
| 2019 оны дүн | | 1,605,394.8 | 844,501.8 | | 1,580,702.0 | |

Замын сангийн 2019 оны хөрөнгө оруулалтын гэрээт ажлуудаас Баянхонгор сумын 4, 5 дугаар багуудын тус бүр 5,000.0 мянган төгрөгийн нийт 10,000.0 мянган төгрөгийн ажлыг "Хот тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ- нь хийж гүйцэтгээгүй байна.

Дээрх зөрчлийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хяналт шалгалтаар илрүүлж төлбөрийн акт тогтоон барагдуулсан байна.

Мөн дээрх шалгалтаар Хонгор хотхоны баруун талаас Баянхонгор зочид буудал хүртэл цагариган гэрэлтэй шон-9ш, Leat light-16ш, albero light-3, Дөрвөн замын уулзвараас Мазаалай паркийн зүүн уулзвар хүртэл leat light-12ш, albero light 16ш, дээгүүр явах одон гэрэл дутуу байгаа leat light-12ш, 80м урт туузан гэрэл хийгээгүй байсанд албан шаардлага өгсөн байна.

Замын сангийн хөрөнгөөр 2020 онд 740,664.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 929,407.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 854,858.2 мянган төгрөгийн гэрээний дүнттэй 729,366.1 мянган төгрөгийн санхүүжих төсөвтэй 11 хөрөнгө оруулалтын ТАХ батлагдан гэрээ байгуулан ажилласан байна.

Хүснэгт № 7 Авто замын сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | ИТХ-аар баталсан дүн | Гүйцэтгэгчийн нэр | Гэрээ байгуулсан дүн | Гэрээ байгуулж, хүлээн авсан огноо |
|----|--|------------------|----------------------|--|----------------------|------------------------------------|
| 1 | Баянхонгор сумын төвд 1 км хатуу хучилттай автозам барих /Баянхонгор аймаг. Баянхонгор сум/ | 380,000.0 | 326,257.1 | "Их богд зам" ХХК | 380,000.0 | 2020.08.30-2020.06.16 |
| 2 | Баянхонгор сумын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам тавих, хуучин зам засварлах | 145,000.0 | 120,000.0 | "Их богд зам" ХХК | 137,768.9 | 2020.06.25-2020.10.16 |
| 3 | Загийн гол, Бөмбөгөрийн Өлзийт гол, Түйн гол, Нарийний голын хоолтын гарамнуудад төмөр бетонон гүүрний зураг хийлгэх | 160,000.0 | 80,000.0 | "Кадсүрвэй" ХХК | 90,000.00 | 2020.06.25 |
| | | | | "Тарваченбүүлэн" ХХК | 69,654.7 | 2020.06.25, 2020.12.14 |
| 4 | Аймгийн төвийн хатуу хучилттай автозамуудын зорчих хэсэгт нөхөөсний засвар хийх | 80,000.0 | 80,000.0 | "Их богд зам" ХХК | 79,999.7 | 2020.06.20-2020.10.05 |
| 5 | Шаргалжуут рашаанаас Тосгон хүртэлх замын засвар | 27,444.9 | 27,444.9 | "Дээд мөнх булаг зам" ХХК | 27444.9 | 2020.11.25- |
| 6 | Төв зам дагуу хийгдсэн ногоон байгууламжийн эргэн тойронд толь байрлуулж, иргэдийн аюулгүй байдлыг хангах | 10,000.0 | 10,000.0 | "Баянхонгор-тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ | 10,000.0 | 2020.07.01-2020.06.18 |
| 7 | Баянхонгор сумын 5.6 дугаар багийн "Наран мандмал" өрхийн эмнэлгийн гадна авто зогсоолын талбай хийх | 10,000.0 | 10,000.0 | "Баянхонгор-тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ | 10,000.0 | 2020.07.01-2020.16.18 |
| 8 | Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Босгын ёроолын шороон замыг засварлах | 10,000.0 | 10,000.0 | "Баян тээг өндөр толгой" ЗНБ | 10,000.0 | 2019.07.10-2020.05.06 |
| 9 | Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Баян давааны шороон замыг засварлах | 10,000.0 | 10,000.0 | "Баян тээг өндөр толгой" ЗНБ | 10,000.0 | 2020.06.25 |
| 10 | Баянхонгор аймгийн Хөх толгойн шинэ замын тэмдэг тэмдэглэгээ | 10,000.0 | 10,000.0 | "Өсөх Урам" ХХК | 10,000.0 | 2020.07.07-2020.07.04 |
| 11 | Баянхонгор сумын 2.7 дугаар багийн Шинэ зам дээр Автобусны буудлыг шинэчлэх, нэмэгдүүлэх | 20,664.1 | 20,664.1 | "Дурсамж принт" ХХК | 19,990.0 | 2020.12.15- |
| | 2020 оны дүн | 888,109.0 | 729,366.1 | | 854,858.2 | |

Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх нийт 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажлыг улсын комисст хүлээлгэн өгсөн бол аймгийн төвд 4 ш автобусны буудал нэмэгдүүлэх ажил, ажил гүйцэтгэх гэрээг сунгаагүй ажлыг хийгээгүй байсан аймгийн Санхүү, хяналт аудитын алба ажлыг гүйцэтгэх албан шаардлага өгчээ.

Баянхонгор аймгийн Санхүү, хяналт аудитын албанаас хийсэн шалгалтаар Баянхонгор сумын хатуу хучилттай зам дагуу 3300 м.кв явган хүний зам тавих, хуучин зам засварлахаар төлөвлөсөн ажлыг "Их богд зам" ХХК нь 2,402.6 м.кв зам тавьж 897.4 м.кв явган хүний зам дутуу хийж хүлээлгэн өгсөн зөрчил илэрсэнд улсын байцаагчийн албан шаардлага өгч дутуу ажлыг гүйцээж хийхээр тохиролцсон байна.

Ангилалдаагүй зардлын жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ангилалдаагүй зардлаас 2019 онд 22 төсөл арга хэмжээний 1,490,456.9 мянга, 2020 онд 22 төсөл арга хэмжээний 1,612,823.8

мянган төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулан ажилласан байна.


Дүрслэл №1. Ангилагдаагүй зардлаас 2019, 2020 онд санхүүжүүлсэн ТАХ-ний ангилал



Ангилагдаагүй зардлаас 2019 онд 1,422,436.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн бол 2020 онд 1,551,343.4 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Зардлын ангиллаар авч үзвэл:

- *Шаардлагатай автомашинаар хангах зардалд 2019 онд 543,800.0 мянган төгрөг буюу 38.2 хувийг эзэлж байхад 2020 онд 355,500.0 мянган төгрөг буюу 22.9 хувь,*
- *Барилга байгууламж, урсгал засварт 2019 онд 268,536.4 мянган төгрөг буюу 18.9 хувь байсан бол 2020 онд 134,259.1 мянган төгрөг буюу 8.6 хувь,*
- *иргэдэд орон сууцны дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрт 2019 онд 135,000.0 мянган төгрөг буюу 9.5 хувь 2020 онд 378,000.0 мянган төгрөг буюу 24.3 хувь,*
- *Газар тариалан ЖДҮ-ийг дэмжих санхүүжилт 2019 онд 60,000.0 мянган төгрөг буюу 4.2 хувь байсан бол 2020 онд 260,000.0 мянган төгрөг буюу 16.7 хувь тус тус эзэлж байна.*

Дүрслэл №2. Ангилагдаагүй зардлаар бэлтгэсэн авто машины талаарх мэдээлэл



Аудитаар ангилагдаагүй зардалд гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс Соёл урлагийн байгууллагуудад автомашин нийлүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд “Баян арвижих од” ХХК нь Гурванбулаг сумын Соёлын төвийн автомашиныг гэрээнд зааснаар 2019.07.07-ны өдөр нийлүүлэх байсан бөгөөд 2017.07.23-ны өдөр уг тээврийн хэрэгслийг хүлээлгэн өгч 24 өдрөөр гэрээнд заасан хугацаанаас хоцорсноос бусад аж ахуйн нэгжүүд нь гэрээт хугацаанд үүргээ биелүүлсэн байна. Иймд гэрээнд заасны дагуу гэрээний нэг хувь буюу 280.0 мянган төгрөгийн алдангийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Харин Баянхонгор аймгийн агаарын тээврийн нислэгийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээг Жаргантай хөх тариа ХХК-тай 2020.08.31-ны өдрийн 2020/135 тоот 116,480.4 мянган төгрөгийн өртөг бүхий гэрээг байгуулахдаа 2020 онд 70,000.0 мянга, 2021 онд 46,480.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгох бөгөөд тус ажлыг гүйцэтгэгч байгууллага 2020.09.05-ны өдрөөс эхлэн 2020.10.20-ны өдөр захиалагч байгууллагад хүлээлгэн өгөхөөр байгуулсан бөгөөд гэрээнд заасан хугацаанд тус ажлыг дуусгавар болгон захиалагч талд хүлээлгэн өгөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн агаарын тээврийн нислэгийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээг Жаргантай хөх тариа ХХК-тай байгуулсан гэрээгээр 2020.10.21-ны өдөр ажлыг гүйцэтгэн захиалагчид хүлээн өгөхөөр заасан байсан бөгөөд 2021.05.12-ны өдрийн аудитаар хийсэн хяналтын явцад тус компани ажлыг бүрэн хийж дуусгаагүй 85 хувийн гүйцэтгэлтэй гэрээнд заасан хугацаанаас 204 хоног хэтэрсэн ба ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгөөгүй байна.

Иймд дээрх зориулалт бусаар зарцуулсан “Жаргантай хөх тариа” ХХК-ийн гүйцэтгэж буй Нисэх буудлын барилгын гадна фасадын 70,000.0 мянган төгрөгийн ажлын зөрчлийг арилгах албан шаардлагыг ХОХБТХ-т хүргүүлэв.

Мөн төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг хүлээн авсан бараа, ажил үйлчилгээтэй тулгахад тээврийн хэрэгслийн үйлдвэрлэсэн болон импортлогдож орж ирсэн огноо техникийн тодорхойлолтод нийцэхгүй байх, тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрчилгээг олгохдоо автомашины маркийг зөрүүтэй бичих зэрэг зөрчил илрэв. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

1. Сумдын ЗДТГ-ыг автомашинаар хангах төсөл арга хэмжээнээс 2019 онд Баянбулаг сумын ЗДТГ нь “Хангал цэнгэл” ХХК-тай Ланд крузер-105 маркын 48,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг худалдан авах гэрээний техникийн тодорхойлолтод 2007 оноос хойш Монголд орж ирсэн гэж заасан байхад 2006 онд орж ирсэн автомашин авсан.
2. Цаг уур, орчны шинжилгээний алба нь “Бадрах Азийн гэгээ” ХХК-тай 32,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Ланд крузер-100 маркийн автомашиныг худалдан авах гэрээний техникийн тодорхойлолтод Үйлдвэрлэсэн он 2004 ба түүнээс дээш Монголд орж ирсэн нь 2012 он ба түүнээс хойш гэж зааж өгсөн байхад Үйлдвэрлэсэн он 1998 он, Монголд орж ирсэн нь 2008.09.25-нд орж ирсэн автомашиныг 2019.11.20-ны өдөр хүлээлгэн өгсөн.
3. 2020 онд Баян-Овоо сумын ЗДТГ нь иргэнтэй Ланд крузер-200 маркын автомашин худалдан авах гэрээний техникийн тодорхойлолтод Монголд орж ирсэн нь 2018 онд орж ирсэн гаалийн бичигтэй гэж заасан байхад 2011.03.24-нд монголд орж ирсэн автомашиныг 2020.07.08-ны өдөр хүлээлгэн

өгсөн бөгөөд тус автомашинууд нь гэрээнд заасан техникын тодорхойлолтоос зөрүүтэйгээр бэлтгэн нийлүүлсэн зэрэг зөрчлүүд илрэв.

Иймд автомашиныг захиалагчийн техникийн тодорхойлолтоос зөрүүтэй нийлүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, нийлүүлэгдсэн автомашиныг хүлээн авсан холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудад хариуцлага тооцох зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгөв.

Үйлдвэржилт хөгжлийн корпорацаар дамжуулан олгосон ЖДҮ-ийг дэмжих зээл

2020 онд Үйлдвэржилт хөгжлийн корпорацаар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон 200,000.0 мянган төгрөгийн зээлийн зарцуулалтыг шалгахад ҮХК-аас судалгаа гаргуулан авахад 2020 онд олгосон 450,000.0 мянган төгрөгийн 38 зээлдэгчийн жагсаалтыг ирүүлэв. Ирүүлсэн зээлдэгчдийн жагсаалтаас Баянхонгор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 368,000.0 мянган төгрөгийн 30 зээлдэгчээс түүвэрлэн 210,000.0 мянган төгрөгийн 13 зээлдэгчийн үйл ажиллагаа зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд тулгалтыг хийсэн ба 82,000.0 мянган төгрөгийн 8 зээлдэгч нь хөдөө сумдад харьяатай тул газар дээр нь очиж үзэх боломжгүй байв.

Аудитаар Баянхонгор сумд харьяалалтай нийт 210,000.0 мянган төгрөгийн 13 зээлдэгчийн ажлын байранд очиж зээлийн зориулалтыг шалгахад нийт 25,000.0 мянган төгрөгийн 2 зээлдэгч зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Иргэн Б.Дарьсүрэн нь “Хүүхдийн дээл хувцас, баривч өлгий үйлдвэрлэл” төслөөр 15,000.0 мянган төгрөгийн зээлийн хөрөнгөөр дээл, өлгий үйлдвэрлээгүй ба Улаанбаатар хотод захиалан бэлэн бүтээгдэхүүн авчран өөрийн хүүхдийн хувцас худалдаалдаг дэлгүүрт худалдан борлуулж байна.
- Иргэн Б.Алтанчимэг нь “Баянбүрд бариа засал” төсөл хэрэгжүүлж байгаа боловч зээлийн зориулалт бусаар зарцуулж, нийтийн хоолны зориулалтаар ашигласан.

Иймд дээрх зориулалт бусаар ашигласан 40,000.0 мянган төгрөгийн 3 зээлдэгчийн зээлийн хөрөнгийг Үйлдвэржилт хөгжлийн корпорацын дансанд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Мөн аудитаар шалгах үеэр зарим тоног төхөөрөмж ирээгүй боловч үй ажиллагаа хэвийн явагдаж байгаа нийт 75,000.0 төгрөгийн 4 зээлдэгчид үйл ажиллагаа жигдрээгүй байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Иргэн П.Бямбадэлгэрийн “Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэл” төслийн 20,000.0 мянга төгрөгийн зээл аваад үйл ажиллагаа явуулаагүй ба техник тоног төхөөрөмжөө авсан Улаанбаатар хотод байгаа одоогоор ирээгүй байна гэх тайлбарыг өгсөн боловч нотлох боломжгүй байна.
- Иргэн Б.Мөнгөнтуулын “Хөнгөн блокны үйлдвэрлэл” төслийн 30,000.0 мянган төгрөг

- Иргэн О.Цэвэлмаагийн “Бариа засал гоо сайхны үйлчилгээ” төслийн 10,000.0 мянган төгрөгийн төсөл нь зээлийг бүрэн ашиглаагүй байна.
- Иргэн Ц.Отгонжаргал нь “Арьсан хавтас” үйлдвэрлэх зориулалтаар 15,000.0 мянган төгрөгийн зээл авсан боловч төсөлд заасан үйлдвэрлэл эрхлээгүй Улаанбаатар хотоос бэлэн бүтээгдэхүүн захиалан авдаг бөгөөд төгсөлтийн зургийн цомог хийх үйл ажиллагааг явуулж байна.

Иймд дээрх зээлийн ашиглалтыг сайжруулан хөрөнгийг зориулалтын зарцуулж үйл ажиллагааг жигдрүүлэх хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын талаар:

Ерөнхий боловсролын сургууль 706,244.6 мянга, цэцэрлэг 265,747.4 мянга нийт 706,244.6 мянган төгрөгийн хөрөнгийг 2020 онд батлагдсан төсвийн хөрөнгөөр бэлтгэж бүртгэл тайланд бүрэн тусгаж ажилласан байна. Харин нь 248,165.0 мянган төгрөгийн өртөг бүхий ухаалаг самбар нь бэлтгэн нийлүүлэгчээс захиалагчид хүлээлгэн өгөөгүй байсан учраас санхүүгийн тайлангийн аудитаар авлагаар бүртгэлд тусгасан байсан бөгөөд 2021 оны 1 дүгээр сард гүйцэтгэгч байгууллага тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн байна.

Аудитаар дээрх хөрөнгийг цахимаар хөрөнгийн зургийг болон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн баримтыг авч тулгахад зөрчилтэй асуудал илрээгүй болно.

2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг гэрээний дагуу бүрэн олгосон байна.

Аймгийн ИТХ-ын 16 дугаар хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Аймгийн 2019 оны төсөв батлах тухай" 14/03 тоот тогтоолын 5 дугаар хавсралтаар Замын сангийн хөрөнгө оруулалтаар 11 ажилд 706,089.6 мянган төгрөг, 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16/02 тоот тогтоолын хавсралтаар төсвийн үлдэгдлээс 6 ажилд 198,568.8 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар тус тус баталжээ.

Хүснэгт № 8 Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн судалгаа

/мян.төг/

| № | Зардлын эх үүсвэр | Батлагдсан дүн | | Санхүүжих дүн | | Олгосон санхүүжилт | Дутуу санхүүжилт |
|---|---|----------------|--------------------|---------------|--------------------|--------------------|------------------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Замын сангийн 2019 оны хөрөнгө оруулалт | 17 | 904,658.4 | 17 | 879,956.7 | 852,387.0 | 27,569.7 |
| 2 | Замын сангийн 2020 оны хөрөнгө оруулалт | 13 | 740,664.1 | 13 | 739,989.7 | 728,359.6 | 11,630.1 |
| 3 | Ангилалдаагүй зардалд 2019 оны хөрөнгө оруулалт | 22 | 1,454,956.9 | 22 | 1,452,456.9 | 1,422,436.4 | 30,020.5 |
| 4 | Ангилалдаагүй зардалд 2020 оны хөрөнгө оруулалт | 22 | 1,656,401.0 | 21 | 1,551,343.4 | 1,551,343.4 | 0 |
| | Нийт | 74 | 4,756,680.4 | 73 | 4,623,746.7 | 4,554,526.4 | 69,220.3 |

Жич: Судалгааны дэлгэрэнгүй задаргааг хавсралтаар харуулав.

Замын сангийн 2019 онд хэрэгжүүлэхээр батлагдсан “Гудамжны гэрэлтүүлэг”-ийн ажилд 169,318.2 мянган төгрөгийн гэрээ байгуулснаас тайлант онд гүйцэтгэгчид

135,454.6 мянган төгрөг олгож үлдэгдэл 33,863.6 мянган техник хяналтын дансанд байршуулсан байна. Энэ нь тухай ажлыг бүрэн дуусаагүй байсантай холбоотой бөгөөд энэхүү ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгоходоо хугацаа хоцроосон алдангийг тооцож суутган авахыг аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-т тооцож хариуцуулав.

Аудитын илрүүлэлт:

“Гудамжны гэрэлтүүлэг”-ийн үлдэгдэл санхүүжилт 33,863.6 мянган төгрөгийн төсвийг байршуулахдаа 7,623.9 мянган төгрөгийн “МЦЛ”ХХК-д шилжүүлсэн зураг төсвийн үнэ 4,500.0 мянган төгрөгийн тооцолгүйгээр барьцаа дансанд байршуулсан. Мөн “Их богд” ХХК-аас 1 км авто замын зураг төсвийн үнийг илүү шилжүүлсэн байсныг буцаалтаар 2,068.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Иймд дээрх зураг төсвийн үнийг барьцаа дансанд байршсан 33,863.6 мянган төгрөгийн санхүүжилтээс 4,500.0 мянган төгрөгийг суутган тооцож, 1,055.0 мянган төгрөгийн МЦЛ ХХК-аар төлүүлж, автозамын санд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2019 онд баригдаж эхэлсэн Баянхонгор сумын төвд баригдсан 380,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 км авто замын ажил он дамжин хэрэгжих тухайн онд санхүүжих 53,742.9 мянган төгрөгийн төсвөө бүрэн авсан ба дараа онд 326,257.1 мянган төгрөгөөр санхүүжихээр туссан байна.

Ангилалдаагүй зардлын жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 2019 онд санхүүжих нийт 1,452,456.9 мянган төгрөг олгохоос 1,422,436.4 мянган төгрөг олгож 30,020.5 мянган төгрөгийг санхүүжилтийг олгоогүй байна. Тухайн онд “Халдвартын эмнэлгийн агааржуулалт”-ын төслийг хэрэгжүүлэгч “Бүдума” ХХК-тай оны эцэст буюу 2019.12.17-ны өдөр гэрээ байгуулж санхүүжилтийг олгоогүй байсантай холбоотой ба 2020 онд олгосон байна.

Харин 2020 оны ангилалдаагүй зардалд багтсан 22 төсөл арга хэмжээний жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын ажлын 1,551,343.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүйгээс гэрээнд заагдсан зарим ажил бүрэн хийгдээгүй, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй бараа, ажил хүлээн авсан бөгөөд гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй байна

Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолын хавсралтаар “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 19-т⁶ заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн Тээврийн бодлого-автозамын асуудал хариуцсан мэргэжилтэн

⁶ Улсын замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг Авто замын газар, түүний зохих албад, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын зохих албад хариуцан хэрэгжүүлнэ

замын сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлуудад хяналтыг тавьж ажиллах үүрэгтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ажил нь тоо хэмжээ дутуу, зарим ажил хийгдээгүй, хяналт хийх ажлын зураг, транс нь дутуу тавигдсан байгаагаас үзэхэд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Мөн ангилагдаагүй зардалд батлагдсан төсөл арга хэмжээнд захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул, ажлын хариуцлагагүй байдлаас болж гэрээнд заасан техникийн тодорхойлолтоос зөрүүтэй ажил үйлчилгээг нийлүүлсэн байна.

Энэ талаар холбогдох мэргэжилтнээс тайлбар авахад “анхан шатнаасаа тухайн төсөл арга хэмжээг төлөвлөхдөө тооцоолол буруу хийсэнтэй холбоотой батлагдсан төсөвт өртөг хүрэхгүй байх зэрэг тохиолдлоос болоод гэрээний техникийн тодорхойлолтод заасан дагуу ажил үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй” гэсэн хариулт өгч байгаагаас үзэхэд албан тушаал хариуцсан ажилтны гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй, хуулиа хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Иймд цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулан эрх шилжүүлсэн ТАХ-г хүлээн авахдаа аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсээс бараа ажил үйлчилгээ хүлээн авах комисст оруулан техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, чанартай бараа, ажил үйлчилгээг хүлээн авч, хяналтыг сайжруулах, ажил хариуцсан холбогдох албан тушаалтнуудын мэдлэг чадварыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ, ЗАРИМ ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХ ЭРХИЙН ЗӨРЧИЛТЭЙ БАЙНА


3.1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр дүнг тооцдоггүй зөрчил давтагдан гарч байна

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнг 2019, 2020 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан боловч тухайн тооцсон үр дүн хэт ерөнхий цаашид шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийх боломжгүй байдлаар дүгнэсэн байна. Тухайлбал: Зам талбай, авто зогсоол, гэрэлтүүлэг зэрэг ажлуудад “хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж, иргэдийн аюулгүй байдал хангагдана” гэж ерөнхий байдлаар тусгасан байна. Гэвч тухайн авто зам ашиглалтад орсноор хөдөлгөөний оновчтой шийдэл яаж гарч, асуудал хэрхэн шийдэгдсэн талаар тусгаагүй, гэрэлтүүлгийн ажлын хувь тухайн багийн оршин суугчдын тоо, болон төслийн байнгын ашиг хүртэгч нь хэд байх, аюулгүй байдал хэрхэн хангагдсан талаар тодорхой тусгаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь бодлого хэрэгжүүлэгч, гол үүргийг хүлээсэн хэлтсийн хувьд хөрөнгө оруулалтын үр ашиг тооцох, үр дүнг дүгнэх ажлыг хийдэггүй зөрчил өмнөх жилүүдийн аудитаар давтагдаж байна. Энэ нь орон нутгаас шаардагдах хөрөнгийг шийдвэрлэж ажиллаж байгаа ч гарч буй эцсийн үр дүнг нарийн тооцож гаргаагүйгээс зорилтод түвшнийг хэрхэн хангасан талаар үнэн зөв тооцох боломжгүй болох эрсдэлд хүргэнэ.

Иймд цаашид хөрөнгө оруулалтын үр дүнгийн биелэлтийг тооцож буй байдалд тодорхой тоон үзүүлэлт, гарсан үр дүнг үнэн зөв гаргаж буй эсэхэд бодлогын хэлтэст хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

Дүрслэл № 3 ЖДҮ-ийн үр дүнд бий болсон ажлын байрны судалгаа



Аудитад хамрагдсан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчид Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн копорацийн судалгаа шинжилгээ хариуцсан ажилтан зээлийн ашиглалтын явцад байнгын судалгаа тандалт хийж ажиллаж ирсэн байна.

Энэ судалгаагаар 2020 оны зээлд хамрагдсан 38 зээлдэгч нь нийт 179 ажлын байр бий болгохоор төсөл бичсэн боловч өнөөгийн байдлаар 79 ажлын байр нэмэгдсэн байна. Энэхүү зорилтод ажлын байр хангагдаагүй байдал нь Ковид-19 цар тахалт гарч хязгаарлалтад орсонтой холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Зээлийг олгохдоо төслийн хэмжээнээс хасаж олгосоноос шалтгаалж, зорилтод төсөл хэрэгжих боломжгүй болж төслийн үр дүн хангагдахгүй хөрөнгө мөнгөний эх үүсвэр хүрэлцэхгүй байгаагаас зээлдэгчид тооцоолоогүй нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулж, тооцоолсон үр ашигт хүрэх боломжийг алдагдуулж байна.

Иймд жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор эдийн засгийн үндэслэлд тулгуурлаж цаашид тогтвортой хэрэгжих боломжтой, аймаг эдийн засгийн үр өгөөж, ажлын байр, зэрэг үзүүлэлтийг харгалзан зээлийг олгохдоо үйл ажиллагаа явуулах эсэх талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас тодорхойлолтыг авч, зээлийг олгож байх зөвлөмжийг Үйлдвэржилт хөгжлийн корпорацид хүргүүлэв.

2019 онд “Жимс жимсгэнийн тариаланг дэмжих” төслийн хүрээнд 50,000.0 мянга төгрөгийг нийт 30 айлд мод тарих зорилгоор 6 дугаар багийн нутаг дэвсгэрт гудамжны ард газар олгож бүлэг хэлбэрээр зохион байгуулж хашаажуулан мод тарьж хашаа барьж эхэлсэн байна.

Аудитаар тухайн газар дээр очиж үзэхэд зарим айлын хашаандаа модоо ургуулаагүй орхигдсон байгаагаас үзэхэд төслийн хөрөнгө үр ашиг бүрэн гараагүй байна. Иймд дээрх хөрөнгийн үр ашгийг сайжруулах, мод бут сөөгийг нөхөн тарьж ургуулан төслийн үр ашгийг гаргах албан шаардлагыг Үйлдвэржилт хөгжлийн корпорацид хүргүүлж, албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд буцааж төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргахыг зөвлөв.

2020 онд ангилагдаагүй зардлаас Баянхонгор аймгийн үйлдвэржилт хөгжлийн корпорациар дамжуулан иргэн П.Лхагвасүрэнтэй “Нийтийн тээврийн үйлчилгээний төсөл”-ийн хүрээнд 8 ширхэг “Эко автобус” худалдан авч нийтийн тээврийн ажиллуулах 280,000.0 мянган төгрөгийн зээлийг 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төсөл бичсэн бөгөөд анх төсөл бичиж байх үед 8 авахаар төлөвлөсөн боловч зээл шийдэгдээгүй удааширнаас 7 цахилгаан автобусыг авч бэлтгэсэн байна.

Гэвч нийтийн тээврийн үйлчилгээний үйл ажиллагаа жигдрээгүй, хөрөнгийн үр ашиг гарч эхлээгүй бөгөөд автобуснууд нь төсөл хэрэгжүүлэгчийн нэр дээр өмчлөлтэй бөгөөд Ковид-19 цар тахлаас шалтгаалан зогсолтын байдалд байгаагаас зээлийн эргэн төлөлтийн хуваарь алдагдах эрсдэл үүсэж байна.

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дээрх төслийн хөрөнгийн үр ашгийг гаргах албан шаардлагыг ХОХБТХ-т албан шаардлагаар хүргүүлэв.

3.2. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн боловч зарим хөрөнгө эзэмших эрхийн зөрчилтэй байна

Аудитад хамрагдсан онуудад ангилагдаагүй зардал болон замын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний эзэмшигчийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.12.25-ны өдрийн 122 дугаар тогтоол, 2020.01.21-ны өдрийн 04 тоот, 2021.02.18-ны өдрийн 07 тоот тогтоолуудын дагуу 2019 онд ангилагдаагүй зардалд батлагдсан хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 880,486.4 мянга, 2020 онд 691,823.8 мянга, Замын сангийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 2019 онд 757,250.8 мянга, 2020 онд 469,921.2 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллага өөрийн бүртгэл тайланд бүрэн тусган ажилласан байна.

Аудитаар зарим бүртгэлтэй хөрөнгийг холбогдох тогтоол шийдвэргүй дур мэдэн солих, орон нутгийн хөрөнгөнд бүртгэсэн хэдий ч ашиглалтын гэрээг байгуулаагүй, эзэмшигчийг нь тодорхойлсон хэдий ч хөрөнгийн бүртгэлд тусгаагүй зэрэг алдаа зөрчил илэрсэн нь байгууллагуудын хөрөнгийн бүртгэл тооцоо, хадгалалт хамгаалалт дээр тавих хяналт сул байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67

дугаар зүйлийн 67.1⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6⁸ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

Аудитаар ангилагдаагүй зардлаас санхүүжсэн төсөл арга хэмжээнээс:

1. Баян-Овоо сум Соёлын төв нь Grand Starix маркын мөнөөлөг саарал өнгийн 2009 онд үйлдвэрлэгдсэн автомашиныг байгууллагын хөрөнгийн дансанд 2019.05.17-ны өдөр бүртгэсэн боловч тус автомашиныг 92-81УНВ улсын дугаартай 2004 онд үйлдвэрлэгдсэн NISSAN CARAVAN маркын 2019.09.28-ны өдөр Монголд орж ирсэн 92-81УНВ улсын дугаартай автомашинаар холбогдох тушаал шийдвэргүй сольсон бөгөөд тус автомашины тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрчилгээ нь иргэн Сандуйгийн нэр дээр бүртгэлтэй байна.

2. Аймгийн Онцгой байдлын газрын албан хэрэгцээнд олгосон Ланд крузер-200 маркын автомашиныг аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019.12.25-ны өдрийн 122 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан 2020.01.21-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Орон нутгийн өмчид орлогоор бүртгэж ашиглалтын гэрээ байгуулах гэж өөрчлөлт оруулсантай холбоотой Орон нутгийн өмчийн алба хөрөнгөнд бүртгэсэн авсан боловч одоог болтол ашиглалтын гэрээг байгуулаагүй байна.

Иймд Баян-Овоо сумын соёлын төвийн авто машиныг шийдвэргүйгээр дур мэдэн сольсон холбогдох эрх бүхий албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Засаг даргад, эзэмшигчийн гэрчилгээг өөрийн байгууллагад бүртгүүлэхийг Баян-Овоо сумын соёлын төвийн эрх бүхий албан тушаалтанд, Онцгой байдлын автомашинд ашиглалтын гэрээ байгуулж ажиллахыг аймгийн ОНӨГ-ын дарга нар тус тус зөвлөмжөөр хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016.02.26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 1,072м² хэмжээтэй 1979.01.01-ны өдөр ашиглалтад орсон Бууцагаан сумын хуучин конторын 2 давхар барилгыг худалдах доод үнэ 96,286.4 мянган төгрөгөөр тогтоон дуудлага худалдааг зохион байгуулж иргэн Ц.Лхагвасүрэн 78,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Үүнтэй холбоотой тус барилгыг 2017.12-р сард сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлээс хассан байна. Харин Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.04.19-ний өдрийн 36 дугаар тогтоолоор 2016 оны 10-р тогтоолын 1-р хавсралтад заасан " Бууцагаан сумын Засаг даргын конторын барилга" гэсэн хэсгийг хүчингүй болгосугай дээрх тогтоол гарсантай холбоотой барилгыг худалдан авсан иргэнийг хохиролгүй болгох шийдвэр гарч Ц.Лхагвасүрэнтэй худалдах худалдан авах гэрээг 2019.04.08-ны өдөр хийж ангилагдаагүй зардлаас 129000,0 мянган төгрөг олгож худалдсан барилгыг буцааж авсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дээрх барилгын 2 давхар 389,3м² талбай бүхий барилга, урд жигүүрийн зүүн талын 187,4м² гражийн хамт 2018.05.02-ны өдрийн 54-р тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсэн боловч аль ч байгууллагын данс бүртгэлд бүртгээгүй байна.

⁷ "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна"

⁸ "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"

Иймд дээрх 129,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хариуцуулан өглөө.

Мөн аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас хийсэн шалгалтаар нягтлан бодох бүртгэлийн бүртгэл тайлантай холбоотой дараах зөрчлийг илрүүлсэн байна.

Авто замын сангийн 2019 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Жишиг гудамж төслийн хүрээнд Мэргэжлийн хяналтын газрын урьд замын уулзвараас Солонго бичиг хэргийн дэлгүүрийн арын уулзвар хүртэлх гэрэлтүүлгийн ажлыг 2018-2019 онуудад “Алтан завьяа ундарга” ХХК гүйцэтгэсэн боловч Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн Замын сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай 02 дугаар тогтоолын хавсралтаар гэрээний дүн дүнгийн өртөг 76,975.5 мянган төгрөг, 2019 онд зарцуулсан 14,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг Баянхонгор Эрчим Хүч ЦТХХК-ийг задалж хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн байхад бүртгэлд тусгаагүй.

Аудитаар нийт 887,876.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 30,555.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 604,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 253,321.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Ангилалдаагүй зардалд батлагдаж байгаа орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагын судалгаагүй, холбогдох хэлтэс нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төслийг аймгийн төсөв баталснаас хойш боловсруулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.
3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй 199,501.0 мянган төгрөгийн 6 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан.
4. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу цахимаар зохион байгуулсан бөгөөд Баянхонгор сумын Засаг дарга нь ТБОНӨХБАҮХАТХ зөрчиж “Төмс хүнсний ногоо-4” төслийн хүрээнд 52,620.9 мянган төгрөгийн 2 ажлын гүйцэтгэгчийг тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн гэрээний зарим ажил дутуу, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй байна.
6. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгохдоо төслийн хэмжээнээс хасаж олгосноос төлөвлөсөн үр ашигт хүрэх боломжийг алдагдуулж байна.
7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг гэрээний дагуу бүрэн олгосон байна.
8. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр дүнг тооцдоггүй, захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
9. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч нь эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр сольсон, төсвөөс хөрөнгө зарцуулж худалдан авсан хөрөнгийн эзэмшигч тодорхойгүй байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Э.ЭНХБАТ ТАНАА:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан, зорилтод хүрэх түвшнийг тодорхойлсон төсөл арга хэмжээ баталж байх.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ аймгийн хэмжээний төсөв захирагчдын хэрэгцээ шаардлагыг судалж, ач холбогдлоор нь эрэмбэлэн төлөвлөлтийг зохистой хийж, холбогдох албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулахдаа замын цагдаа, баг хорооны саналыг авч, зураг төсвийг урьдчилан боловсруулж, магадлалын дүгнэлт гаруулсны дараа батлуулж, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.
3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний эрх шилжүүлэхдээ багцаар баталсан төсөл арга хэмжээний үнийн дүнг хянаж батлагдсан төсвийн хүрээнд эрх шилжүүлж ажиллах.
4. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулан эрх шилжүүлсэн ТАХ-г хүлээн авахдаа аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсээс бараа ажил үйлчилгээ хүлээн авах комисст оруулан техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, чанартай бараа, ажил үйлчилгээг хүлээн авч, хяналтыг сайжруулах.
5. Хөрөнгө оруулалтын үр дүнгийн биелэлтийг тооцож буй байдалд тодорхой тоон үзүүлэлт, гарсан үр дүнг үнэн зөв гаргаж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.
6. Баян-Овоо сумын соёлын төвийн авто машиныг шийдвэргүйгээр дур мэдэн сольсон холбогдох эрх бүхий албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох.

ГУРАВ. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ИДЭРМӨНХ ТАНАА

1. Засаг даргад, эзэмшигчийн гэрчилгээг өөрийн байгууллагад бүртгүүлэхийг Баян-Овоо сумын соёлын төвийн эрх бүхий албан тушаалтанд, Онцгой байдлын автомашинд ашиглалтын гэрээ байгуулж ажиллах.

**ДӨРӨВ. БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН КОРПОРАЦЫН ДАРГА
Н.БАЯРСАЙХАН ТАНАА**

1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгохдоо зээлийн хорооны шийдвэрээр санхүүжилт нь хасагдсан төслийн зээлдэгчээс үйл ажиллагаа явуулах эсэх талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас тодорхойлолтыг авч, зээлийг олгож байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-oOo-